Ёс зүй хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0,5	0	0
Хэсгийн оноо				**4**	**2**	**20**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх (гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8**	**80**

Ёс зүй хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

НЭГ.Товч танилцуулга
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох журам, Үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 17 агентлаг, харьяа 22 байгууллага, нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газруудад 3-7 хүний бүрэлдэхүүнтэй нийт 55 Ёс зүйн дэд хороо байгуулагдан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйл, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.7-д заасныг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын дунд санал хураалт зохион байгуулж, Тамгын газрын даргын 2024 оны А/151 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн 2025 онд орон гарсантай холбоотой 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Ёс зүйн дэд хороо нь соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх", Ёс зүйн зөрчил, эрх зүйн үндэслэл, хариуцлага", "Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага", "Төрийн албан хаагчийн ёс зүй" сургалтыг Тамгын газар болон Нийслэлийн харьяа агентлагийн дарга нар, ёс зүйн салбар хорооны гишүүд, нийслэл, дүүргийн байгууллагуудын төрийн албан хаагч нарт ёс зүйн сургалтыг байгууллагын төлөвлөгөөнд тусгаж зохион байгуулсан. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хянан шийдвэрлэж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, Ёс зүйн дэд хорооны даргаар батлуулж, төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдүүлэх, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гаргасан зөрчилд хяналт тавих, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор тодорхой ажлуудыг хэрэгжүүллээ.
ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, Ёс зүйн дэд хорооны даргаар батлуулж, төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдүүлэх, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гаргасан зөрчилд хяналт тавих, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор тодорхой ажлуудыг хэрэгжүүллээ.

• Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тайлант хугацаанд төлөвлөгөөт Ёс зүйн сургалтад нийслэлийн нутгийн захиргааны 37 байгууллагын давхардсан тоогоор 582 албан хаагчийг хамруулсан. Үүнд:

1.Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх 5 удаагийн 11 цагийн сургалтад 7 байгууллагын 89 албан хаагч

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь 10 удаагийн 37 цагийн сургалтад 24 байгууллагын 292 албан хаагч

3.Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага 5 удаагийн 12 цагийн сургалтад 6 байгууллагын сургалтад 76 албан хаагч

4.Төрийн албан хаагчийн ёс зүйн ойлголт сэдэвт 2 удаагийн 2 цагийн сургалтад 1 байгууллагын 20 албан хаагч

5.Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын зохион байгуулалт сэдэвт 2 удаагийн 8 цагийн сургалтад ННЗ-ы 5 байгууллагын 105 албан хаагчийг хамруулсан. Сургалтын дараах сэтгэл ханамжийн үнэлгээ: 95% байна.

• Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Ёс зүйн хорооны гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш М.Цэрэнбат (Ph.D)-тай хамтран 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад нийт 150 гаруй албан хаагчийг хамруулсан.

• Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр НЗДТГ-ын нийт албан хаагч нарт зориулж Монгол Улсын төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич, МУИС-ийн Эмерит профессор, Япон Улсын Нагоягийн их сургуулийн хүндэт доктор С.Нарангэрэл нь "Хүмүүн байхын учир ёс суртахуунд нь оршвой" сэдэвт сургалтыг орсон.

• Монгол Улсад Төрийн албаны зөвлөл үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" Нийслэлийн бүсийн зөвлөгөөний хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ" хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Уг арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр батлуулан зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцох яам, агентлагийн 50, яам агентлагаас томилдог удирдлагатай байгууллагын 9, нийслэлийн Засаг даргаас томилдог удирдлагатай байгууллагуудын 23, дүүргийн Засаг даргын Тамгын газруудын 16, дүүргийн Засаг дарга томилдог удирдлагатай байгууллагуудын 33, эрүүл мэндийн байгууллагуудын 32, боловсролын байгууллагуудын 137 нийт 300 албан хаагч оролцсон.

• "Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" нийслэлийн зөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 300 сурагчдад зориулсан "Төрийн алба-Бидний ирээдүй, Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё" арга хэмжээг Нийслэлийн Онцгой байдлын газрын хурлын танхимд 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Төрийн албаны зөвлөл болон Авлигатай тэмцэх газартай хамтран "Төрийн алба-Бидний ирээдүй", "Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё" сэдвээр уулзалт арга хэмжээг зохион байгуулж, мэдээлэл өгч ажиллаа. Уг арга хэмжээнд зориулан "Шударга ёс: Сэтгэхүй хөгжүүлэх бодлого" гарын авлага ном 300 ширхэг, "Сургамжит өгүүллэг" гарын авлага ном 300 ширхэг, "Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?" нугалбар 300 ширхэг, "Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах вэ?" нугалбар 300 ширхэг, Эсгий цүнх 300 ширхэг, Дэвтэр, бал 300 ширхгийг Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн 300 сурагчдад зориулан хэвлүүлж, хүүхэд залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

• Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолын мөрдөж ажиллах чиглэлийг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03/2617 дугаар албан бичгээр нийслэлийн нутгийн захиргааны 81 байгууллагад хүргүүлсэн.

• Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын 2024 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 339-д “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх”-ээр тусгасан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.14-д “Нийслэлийн хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.” гэж тус тус төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд манлайлал үзүүлэн ажиллаж байна.

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжин, сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэх талаар албан хаагчдад чиглэл өгч ажилласан.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороонд 2025 онд 23 өргөдөл, гомдол ирснээс 5 өргөдөл, гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу харьяалах байгууллага руу шилжүүлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт заасны дагуу 4 өргөдөл, гомдлыг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад дүрэм, журмын хүрээнд өргөдлийн хариуг өгсөн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь 2024 онд 4 удаагийн хурлаараа Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагч, харьяа байгууллагын томилох эрх бүхий 6 албан тушаалтан болон харьяа байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2 гишүүнд холбогдох нийт 10 өргөдөл, гомдлыг хэлэлцэж Ёс зүйн зөрчил гаргаагүй тухай 6 дүгнэлт, Ёс зүйн зөрчил гаргасан тухай 1 дүгнэлт, Дүгнэлтийг хүчингүй болгох тухай 2 дүгнэлт, Дүгнэлт хэвээр үлдээх тухай 1 дүгнэлтийг тус тус гарган, томилох эрх бүхий албан тушаалтанд албан бичгээр хүргүүлэн ажилласан.

Ёс зүйн дэд хороонд ирсэн 4 өргөдөл, гомдлыг судалж, ээлжит хурлаар хэлэлцэхээр хянан шалгаж байна.

Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөл болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороонд ирсэн өргөдөл, гомдлын дагуу 2025 оны 02 дугаар тогтоолоор Ажлын хэсэг байгуулж, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, дүгнэлт гарган Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд танилцуулж ажилласан.

Iарсан үр дүн, ололт амжилт:	Ьэрхшээл:
1.Албан хаагчдын ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн; 2.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажил тогтмолжсон; 3.Байгууллагын дотоод сахилга, хариуцлага сайжрах нөхцөл бүрдсэн.	1.Албан хаагчдын ажлын ачаалал ихтэй холбоотойгоор сургалтад хамрагдах цагийн зохицуулалт хүндрэлтэй; 2.Ёс зүйн сургалтыг гүнзгийрүүлэн зохион байгуулахад сургалтын материал, мэргэжлийн сургагч багшийн нөөц хязгаарлагдмал байна; 3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг санхүүжүүлэх боломж бололцоо хангалтгүй; 4.Ёс зүйн дэд хорооны гишүүдийн ажлын ачаалал хэт их.

Санал:
1.Нийслэлийн Засаг даргын орлогчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдлын харьяалалыг тодорхой болгох; 2.Ёс зүйн сургалтыг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулах; 3.Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах; 4.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоод журмыг шинэчлэн сайжруулах; 5.Ёс зүйн дэд хороодын ажлын ачаалаас хамаарч урамшлууллыг тогтолцоог шинэчлэн батлах; 6.Олон талт ажлууд зохион байгуулахад төсөвтэй холбоотой бэрхшээл тулгарах эрсдэлтэй тул нарийвчлан хууль, журманд тусгаж өгөх.

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
/Албан тушаал/ _____ Т.ОЮУНЧИМЭГ
/Гарын үсэг/ */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга:
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
/Албан тушаал/ _____ Ү.ГАНБОЛД
/Гарын үсэг/ */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Төрийн албан хаагчдын ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн
/Албан тушаал/ _____ А.ЭРДЭНЭМӨНХ
/Гарын үсэг/ */Гарын үсгийн тайлал/*